

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Шаравжамц	Дугаар	L074
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Баяндун сум
Төрсөн газар	Дорнод аймгийн Баяндун сум	Төрсөн он	1912
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дорнод аймгийн Баяндун сумын Угтамтэгчинлэн хийд	Сүм хийдийн дугаар	ДОБД 029
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Дорнод аймгийн Баяндун сумын Угтамтэгчинлэн хийд

-Угтамын хийдийн талаар та ярьж өгөөч?

Угтамын хийдийн талаар би сайн мэдэхгүй. Угтамын хийдийн талаар. Тэнд сууж байсан Гонгор гэдэг хүн бий.

-Та тэнд хэдэн настай сууж байсан бэ?

Би нэг 10 хэдтэй л сууж байсан.

-Та аль хийдэд сууж байсан бэ?

Улзын тэндэх. Нэг жижиг цөөхөн ламтай газар байсан. Тэгээд сүүлдээ яахав дээ эсэргүү мэсэргүү болоод.

-Тэр хийд хэдэн онд байгуулагдсан бэ?

1920,30 оны үед болов уу, Угтам бол олон жилийн урьд дээр дээ.

-Баяндунд хэдэн сүм хийд, хүрлын газар байсан бэ?

Угтамын хийд байна. Урдуураа халх талын улсууд суудаг. Хойгуураа голдуу буриадууд суудаг байсан. Хойно чинь Ага, Цүүгэл гээд дацангууд байсан.

-Таны сууж байсан хийд хэдэн дугантай хэр олон ламтай байсан бэ?

Ээ, ганц дугантай. Дуган ч гэж дээ. Тавын банзаар барьсан зуны модон гэр шиг тийм л дуган байсан.

-Хэдэн ламтай байсан бэ?

Одоо нэг 50, 60-аад л ламтай байсан байх даа. Тэгээд 1937 оноос л устсан.Тэр талаар бичиж байсан хүн Дамдинжав гэж хүн аймаг дээр байгаа. Хоёр хүн байсан. Нэг нь нас барсан.

-Таны сууж байсан хийд чинь Дамбадаржаагийн хийд мөн үү? Улзын голын тэндэх.

Тийм. Бас энэ Хужиртайд нэг дуган байсан.

-Баяндунд Угтамын хийд, Дамбадаржаагийн хийд хоёроос өөр ямар хийд байсан бэ?

Өөр газар байгаагүй.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Энэ Дамбадаржаагийн хийд ямар хүний санаачилгаар бий болсон бэ?

Тэрийг хүүхэд байсан болохоор мэдээгүй.

-Хурал номын хувьд Дамбадаржаагийн хийд маань ямархуу хурал ном хурдаг газар байсан бэ?

Цагийн хуралтай байсан. Зуны хурал гэж болдог байсан. Өвөл цагаан сарын хурал гэж хурдаг байсан. Зүгээр л уншлагын газар байсан.

-Та тэнд хурж байхдаа юу судалж байв?

Итгэл мэтгэлхэн л цээжилж байсан.

-Тэнд зохиол бүтээл туурвиж байсан мөн олонд алдаршсан хутагт хувилгаад байсан уу?

Үгүй ээ, үгүй. Тийм хүн байгаагүй. Харин Цүүгэл дацангийн зурхайч Балдан гэдэг хүн байсан. Баригдаад явсан.

-Дамбадаржаагийн хийдэд ном барладаг байсан уу?

Үгүй, үгүй, үгүй.

-Өөр тэр хуралд ямар онцлог зүйл байв?

Өөр ч юм байгаагүй. Угтам ч яахав олон жилийн түүхтэй. Олон ч хүнтэй байсан.

-Таны сууж байсан хийдийн мяндагтан лам нар нь хэн хэн гэсэн хүмүүс байсан бэ?

Хийдийн тэргүүн хамба нь Жамъян гэдэг хүн байсан. Ловон, ширээт гэж нэг л хүн байсан. Тэр Жамъян гэдэг хүн. Жанчивдорж гэж унзад байсан. Эсэргүү болж баригдаад ирээд нас барсан.

-Гэсгүй нь хэн гэдэг хүн байсан бэ?

Байсан л байх даа. Тийм олон жил болоогүй газар шүү дээ. Цуглаад л хурал хураад л тардаг тийм л газар байсан.

-Хийд хаагдаж балрах үеийн тухай?

Тараад л байшин сав суулгыг сүм л авсан байх даа. Голдуу сургууль мургуулийн байр сууц барихад л банзыг нь авсан байх. Банзан байшин байсан.

-Тэр хийдэд хурж байсан лам нар, мяндагтан лам нар бүгд хэлмэгдсэн үү?

За бараг нь хэлмэгдсэн байх даа. Өөр ч юу байхав дээ.